

## Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2016 оны 06 сарын мэдээ

2016 оны 06 дугаар сарын 30

### Байгалийн нөөцийн менежмент

Бат-Өлзий сумын орчны бүсийн менежмент төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулах нь зөвлөгөөнийг 2016.06.07-ны өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Засаг дарга, ЗДТГ, БОХУБ, Төрийн сангийн мэргэжилтэн, Байгаль хамгаалагч, Бүрэгтий багийн ИТХ-ын дарга, Мал эмнэлэгийн үржилийн тасаг, ДӨСДГХЗахиргаа, ОХБЦГХЗахиргаа, ТББ-ын төлөөлөл, 2,4 багийн нөхөрлөлийн багт байрлах нөхөрлөлийн ахлагч, малчдын төлөөлөл зэрэг 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй зөвлөгөөн боллоо.



Тус зөвлөгөөнөөр менежментийн төлөвлөгөөний алсын хараа, зорилго, зорилт, үнэт зүйлсийн аюул занал зэргийг тодорхойлж тэдгээрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөгөөг хэлэлцэн орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх боломжуудыг жагсаалтаар гаргаж ОБМТөлөвлөгөөг шинэчилэн боловсрууллаа.



Өвөрхангай аймгийн Хархорин сумын Нарийн хүр, Орхон, Шанх багийн нутагт 1000га, Бат-Өлзий сумын Хятруун, Бөөрөг, Мухдаг, Улаан ам, Хурцын ам, Улиастай гэх газар нутгаар 3000 га талбайд 2016 оны 06 сарын 20-25-ны хооронд МОНТАКСАЦ ХХК хамтран ойн хортон устгалын ажлыг хийж гүйцэтгэн хяналт тавьж ажиллаа.



Орхон голын хог цэвэрлэх хөдөлгөөнийг 2016 оны 06 сарын 10ны өдөр Орхоны хөндийн хамгаалалтын захиргаа, Хархорин сумын ЗДТГ, Түшээ гүн ТББайгуулагатай хамтран зохион байгууллаа. Үүнд: Эрдэнэтолгой, Ганган Орхон, Вангийн овоо багийн ажилгүй 100 иргэнийг хамруулан 4 хэсэг болон Орхон голын 2 талаар голын эргээс 50-100 метр зайтай нийт 80 км газрын хогийг цэвэрлэж 8 машин буюу 16 тн хогийг цэвэрлэн хогийн цэгт асгалаа.



### **Мэдээлэл, сургалт сурталчилгаа**

2016 оны 05 сарын 30-нд Өвөрхангай аймгийн Хархорин суманд Орхон голын сав газрын зөвлөл хуралдлаа.



Тус хуралдаанаар Орхон голын сав газрын зөвлөлийг шинэчлэн байгуулах, оролцох гишүүдийн нэрсийн саналыг хэлэлцлээ.

Усны сав газрын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлогыг танилцуулсан, зөвлөгөөнд БОНХАЖЯам, Усны сав газар, Өвөрхангай, Архангай аймгийн БОАЖГазар, Сэлэнгэ, Булган, Архангай аймгийн сав газрын хамгаалалтын захиргаа, Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны төлөөлөл болох 40 гаруй хүн оролцлоо.

Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээний портал системийн сургалтанд хамрагдлаа. Энэхүү нэгдсэн системийг ашиглах сургалтанд хамрагдсанаар бүх хамгаалалтын захиргаад өөрсдийн мэдээ мэдээллээ оруулах, ТХГН-аа сурталчилах ТХГН дахь жуулчны баазуудын мэдээллийн нэгтгэл удирдах боломжтой боллоо.



Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санаа ойлголтыг бэхжүүлэх нь сэдэвт сургалтанд хамгаалалтын захиргааны мэргэжилтэн Ч.Суурьтогтох хамрагдлаа. Энэ ажлын хүрээнд тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн үзэл баримтлал суурь зарчмуудыг таниулах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх Монгол улсын боломж, сорилт, олон улсын туршлагын талаар мэдлэг олгож, олон нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол, ногоон хөгжлийн бодлогын талаар мэдээлэл хүргүүлэх, сургагч багш бэлтгэх зорилготой сургалт болсон.



Хамгаалалтын захиргаа Орхоны хөндийг тусгай хамгаалалтанд авсаны 20 жилийн ойн арга хэмжээг 7 сарын 21-22 өдрүүдэд зохион байгуулахаар болж хамтрагч байгууллага, иргэддээ урилга, хөтөлбөрөө хүргүүлээд байна.

Эх үрсийн баярт зориулан Хамгаалалтын захиргааны албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч бэлэг өглөө.



ОРХОНЫ ХӨНДИЙН БЦГ-ЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА